

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022 оны 02 дугаар сарын 25

Багануур дүүрэг

№	Үндэслэл	Хийсэн ажлын биелэлт	Гүйцэтгэл, хувь
1	2	3	4
1.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.1	<ul style="list-style-type: none"> <li>- МЕСЕС ХХК-тай хамтран хэзэгжүүлэх паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 6,76км урт 110кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамыг барих ажлын нийт 3,922.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 45%-ийг тус компаниас, 55%-ийг нийслэлийн төсвөөс шийдвэрлүүлэхээр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт талаас уг ажлыг гүйцэтгэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</li> <li>- Дээрх бүтээн байгуулалтын ажлын дагуу нийслэлийн төсвөөс батлагдсан 2.174.1 сая төгрөгийн санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлүүлэх талаар нийслэлийн барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч Б.Сүхбаатар дарга, НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт хариуцсан Ж.Эрдэнэчимэг Ахлах мэргэжилтэн, Худалдан авах ажиллагааны газрын Зураг төсөв хариуцсан Б.Амарболд мэргэжилтэн нартай уулзалт зохион байгуулж үүрэг чиглэл авч ажиллаж байна.</li> </ul>	100
2.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.2	<ul style="list-style-type: none"> <li>- 2022 онд Паркийн үндсэн 110кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах 6,76км урт агаарын шугамыг барих ажил эхлэхтэй холбогдуулан НИТХ-ын чуулганаар нийслэлийн 2022 оны төсөвт тусгагдсан 1,174.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт НЗД-ын А/170 дугаар захирамжаар баталгаажсан.</li> <li>- НЗД-ын 02 дугаар сарын 17-ны өдрийн А/212 дугаар захирамжийн хүрээнд дээрх бүтээн байгуулалтад шаардлагатай материалыг нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт 02 дугаар сарын 18-ны өдрийн 17 дугаартай албан бичгээр болон amaraabasan24@gmail.com цахим хаягаар, нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт 02 дугаар сарын 21-ний өдрийн 19 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.</li> <li>- Төсөвт тусгасан хөрөнгө оруулалтаар сонгсон шалгаруулалт хуулийн хугацаанд зарлагдана.</li> </ul>	100
3.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.3.3	Паркийн үндсэн нэгж Монхимо ХХК-ийн үйл ажиллагааг байгууллагын цахим хуудсаар дамжуулан сурталчилж байна.	100
4.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.4	НЗДТГ-аас зохисон байгуулсан хяналт шалгалтын үеэр өгсөн зөвлөмжийн хүрээнд байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсан.	100
5.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.4	Байгууллагын Дотоод хяналт шалгалтын комиссын ажиллах журам, Ёс зүйн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж Газрын даргын 02 дугаар сарын 10-ны өдрийн А/04, А/05 тушаалаар батлан, албан хаагчдад танилцуулж, мөрдлөг болгон ажиллаж байна.	100

1	2	3	4
6.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.1	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найрууллагын хүрээнд албан хаагчдын хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулсан. Нийслэл, дүүргийн төрийн захиргааны төв байгууллагаас зөвлөмж авч эцэслэн баталгаажуулахаар болсон.	90
7.		НЗДТГ-аас зохион байгуулсан Хяналт шалгалтын үеэр өгсөн зөвлөмжийн хүрээнд Албан хаагчдын ажил дүгнэх журмын 2.2 дахь заалтыг үндэслэн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтэд зохих өөрчлөлтийг оруулсан.	100
8.		Паркийн бүтэц, зохион байгуулалтад дүн шинжилгээ хийж, ажлын байрны нягтрал уялдаа холбоог сайжруулах хүрээнд чиг үүргийн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг Газрыг даргын 02 дугаар сарын 15-ны өдрийн А/06 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажилласан.	100
9.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.3	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын байрны дүн шинжилгээний хүрээнд албан хаагчдын ажлын ачааллын байдалд дүн шинжилгээ хийсэн.</li> <li>- Ажлын ачаалал тэнцвэртэй байна гэж үзсэн.</li> </ul>	100
10.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.4	<ul style="list-style-type: none"> <li>- Багануур дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төвөөс 2021-2022 оны хичээлийн жилд авах сургалтын саналын дагуу 16-нд зохион байгуулагдсан гар урлалын чиглэлийн сургалтад 2 албан хаагч хамрагдсан.</li> <li>- Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн “Архив, албан хэрэг хөтлөлтийн шинэчлэгдсэн журмын танилцуулга” арга зүйн сургалтыг 02 дугаар сарын 15-ны өдөр нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан.</li> <li>- Удирдлагын академиас зохион байгуулсан “Ахисан түвшний Жөндөрийн дүн шинжилгээ” онлайн сургалтад албан хаагчдыг хамруулсан.</li> </ul>	100
11.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.13	<ul style="list-style-type: none"> <li>- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд ирсэн ЗГ-ын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 07 дугаар тогтоол, НЗД-ын А/170, А/212 дугаар захирамж, Ковид цар тахалтай холбогдон гарсан ЗГ-ын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоол, УОК-ын Шуурхай ажлын хэсгийн 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэл, НОК-ын Шуурхай штабын 02 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар хурлын тэмдэглэл, НЗД-ын А/01 дүгээр захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</li> <li>- Мөн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, албан хаагчдын ажлын биелэлтэд хяналт тавьж байна.</li> </ul> <p>НЗДТГ-ын 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/562 дугаартай албан бичгийн дагуу Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх, танилцуулах асуудлын талаарх саналыг бэлтгэн 02 дугаар сарын 15-ны өдрийн 13 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.</p>	100
12.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3.2	<ul style="list-style-type: none"> <li>- 2021 онд үүсч хөтлөгдсөн баримт бичгийг албан хаагчдаас үе шаттайгаар хүлээж авч байна.</li> <li>- Захирамжлалын баримт бичгүүдийг (А тушаал-20, Б тушаал-25) скандаж archive.mn программд оруулж нягтлан шалгасан.</li> </ul>	100

1	2	3	4
13.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3.4	<ul style="list-style-type: none"> <li>- Удирдлагын академаас зохион байгуулсан сургалтад оролцож сертификат авсан тухай мэдээллийг “Хүний нөөцийн удирдлага” дэд системээр албан хаагчдын хувийн хэрэгт бүртгэлжүүлэн баяжилт хийсэн.</li> <li>- “Цаг бүртгэлийн дэд систем”-д Улс, нийслэлийн Онцгой комиссын шийдвэрийн хүрээнд 02 дугаар сарын 18-ны өдрийг дуусталх хугацаанд 2 албан хаагчийг цахимаар ажиллуулж цахим бүртгэлийг бүртгэлжүүлсэн.</li> <li>- “Мэдэгдэл дэд систем”-д тавигдсан мэдээлэлтэй албан хаагчид тухай бүр танилцан ажиллаж байна.</li> <li>- “Ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгавар дэд систем”-д тайлант сард 3 үүрэг даалгавар удирдлагаас холбогдох албан хаагчдад хуваарилагдаж, албан хаагчид заасан хугацаанд шийдвэрлэсэн.</li> <li>- “Судалгаа” дэд системд тайлант сард тавигдсан UB ERP системийн сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчид бөглөсөн.</li> <li>- Иргэн албан хаагчаас гаргасан өргөдлийг “Өргөдөл гомдлын дэд систем”-д тухайн өргөдлийн шинж чанараас хамааран албан хаагчдаас ирсэн өргөдлийн ангилалаар бүртгэж цаг тухайд нь даргын тушаалаар шийдвэрлэн хариуг холбогдох эзэнд нь даруй мэдээлж ажилладаг. Тайлант сард иргэн, албан хаагчаас ирсэн өргөдөл, гомдол байхгүй.</li> <li>- “Үйл явдлын дэд систем”-д тавигдсан мэдээлэлтэй албан хаагчид тухай бүр танилцан ажиллаж байна.</li> </ul> <p>“Албан хэрэг хөтлөлтийн edoc дэд систем”-ээр:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 02 дугаар сарын 01-25-ны өдрийн байдлаар хариутай 7, хариугүй 8 нийт 15 албан бичиг ирсэн. Албан бичгийн шийдвэрлэлт, хаалт тус бүр 100%. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2.00 хоног.</li> <li>- “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас дээрх хугацаанд хариутай 1, хариугүй 12 нийт 13 албан бичгийг нийслэл, дүүргийн газар, хэлтсүүдэд явуулсан. Шийдвэрлэлт 100%.</li> </ul>	100
14.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.6.1	<p>Байгууллагын цахим хуудасны хөтлөлтийг тогтмол хийж, мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. 02 дугаар сарын 01-25-ны өдрийн байдлаар нийт 25 мэдээллүүдийг байршуулан ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол бичгийн мэдлэг, мэдээлэл түгээх чиглэлээр 8</li> <li>- Байгууллагын үндсэн чиглэлтэй холбоотой цаг үеийн мэдээлэл 1</li> <li>- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 8</li> <li>- Хүний нөөцийн чиглэлээр 1</li> <li>- Ковид цар тахалтай холбоотой зөвлөмж 6, шийдвэр 1</li> </ul>	100
15.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.1.1	<ul style="list-style-type: none"> <li>- 2022 оны төсвийн хуваарийн дагуу 02 дугаар сарын санхүүгийн гүйлгээг зохих журмын дагуу хугацаанд нь хийлгэсэн.</li> <li>- Нийслэл дэх Төрийн Аудитын газрын Ш.Мөнхжаргал аудиторт байгууллагын 2021 оны санхүүгийн баримт бичгийг хянуулахаар хүргүүлсэн.</li> <li>- Нийслэлийн Өмч ашиглалт, удирдлагын газрын Х.Баттуяа мэргэжилтэнд байгууллагын 2021 оны санхүүгийн тайланг 02 дугаар сарын 09-ний өдөр хүргүүлсэн.</li> </ul>	100

1	2	3	4
16.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.1.8	<a href="http://www.shilendans.mn">www.shilendans.mn</a> сайтанд байгууллагын санхүүгийн мэдээллийг агуулга стандартын дагуу байршуулж байна.	100
17.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.1.1	Паркийн нийгмийн хариуцлагын хөтөлбөрийг боловсруулж Газрын даргын 02 дугаар сарын 18-ны өдрийн А/08 дугаар тушаалаар батлуулсан.	100
18.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.1.2	Паркийн үндсэн нэгж Монхимо ХХК-ийн нийгмийн хариуцлагын хүрээнд 2021 онд хэрэгжүүлсэн ажлыг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргэж байна.	100
19.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.1.3	<p>Нийслэлийн Онцгой комиссын даргын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 07 тоот албан бичгийн хавсралтаар батлагдсан "Төр хувийн хэвшлийн байгууллагад коронавируст халдвараас сэргийлэх, тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээний түр зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээнүүдийг авч халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллаж байна. Үүнд:</p> <p><u>Байгууллагын дотоод зохион байгуулалтын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө түрээслүүлэгч компанийн ажилтан биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлж байна.</li> <li>- Ажилчдыг паркийн үндсэн нэгж Монхимо ХХК-ийн гар ариутгах болон ам хоолой зайлах уусмалаар тогтмол хангаж байна.</li> <li>- Ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр агааржуулалтыг хийн, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээг зохион байгуулан ажиллаж байна.</li> <li>- Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна.</li> </ul> <p><u>Түр зөвлөмжийн хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- 1.1. Коронавируст халдвараас сэргийлэх талаар ЭМЯ-наас бэлтгэсэн зурагт хуудас, зөвлөмжийг мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.</li> <li>- 1.2. Албан хаагчид амны хаалтыг тогтмол зүүж байгаа ба бохирдсон даруйд сольж байна.</li> <li>- 1.3. Албан хаагчид 1-2метрийн зайг баримтлан ажил үүргээ гүйцэтгэж байгаа ба ажлын байранд хамтарч хооллох, цай уух зэргээр бөөгнөрөл үүсгэхгүй, ойроос харьцахгүй ажиллаж байна.</li> <li>- 1.4. Албан хаагчдыг гар угаах болон халдваргүйжүүлэх нөхцөлөөр ханган ажиллаж байна. Мөн байгууллагад шаардлагатай цэвэрлэгээний материал, холермин зэргээр хангаж, аюулгүй орчинг бүрдүүлэн ажиллаж байна.</li> </ul>	100

1	2	3	4
20.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.1.3	<ul style="list-style-type: none"> <li>- 1.5. Ажлын байранд гадны хүн оруулахгүй байгаа ба иргэд, хөрөнгө оруулагчдад паркийн үйл ажиллагаа, эрх зүйн хүрээний асуудлын мэдээллийг цахим хуудас, утсаар хүргэн ажиллаж байна. Гадны хүн орсх шаардлагатай тохиолдолд QR кодыг уншуулан 1-2м зайг баримталж байна.</li> <li>- 1.6. Ажлын цагаар түрээслүүлэгч компанийн бусад өрөөнүүдээр орохгүй, байгууллагад эрсдэл учруулахгүй ажил үүргээ явуулж байна.</li> <li>- 1.7. Ажлын байранд өдөр бүр 5-10 минутын агаар сэлгэлтийг хийж байна.</li> <li>- 1.8. Ажлын байранд нано, манангаар атомжуулагч ариутгалын төхөөрөмжөөр өрөө тасалгаануудыг халдваргүйжүүлж байна.</li> <li>- 1.9. Байгууллагын нийт 10 албан хаагчаас ковид-19 халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 1-р тунд - 10, 2-р тунд - 8, 3-р тунд – 6 хүн хамрагдсан.</li> <li>- 1.10. Албан хаагчдынхаа дархлааг дэмжих зорилгоор тайлант сард байгууллагын Спорт, Эрүүл мэндийн салбар зөвлөлөөс ковид-19 халдвараас урьдчилан аяныг зохион байгуулан ажилласан.</li> <li>- 1.11. Албан хаагчид айл хэсэхгүй, зочин урихгүй, гэр-ажил-гэр маршрутыг баримтлан ажиллаж байна.</li> </ul> <p>Байгууллагын хэмжээнд ковид-19 халдвар дахин авсан болон бүртгэгдсэн тохиолдол байхгүй.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын Онцгой комиссын Шуурхай ажлын хэсгийн 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэлийн 10 дахь заалтын хэрэгжилтийг ханган 2 албан хаагчийг (0-5 насны хүүхэдтэй эцгийг) 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 02 дугаар сарын 18-ны өдрийг дуусталх хугацаанд цахимаар ажиллуулсан.</li> </ul> <p>Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын 02 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу ЗГ-ын 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Коронавируст халдвар тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын холбогдох заалтын хэрэгжилтийг ханган, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллаж байна.</p>	100
<b>НЭМЭЛТ АЖИЛ</b>			
21.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.4.2	<p>Паркийн Хүнд үйлдвэрлэлийн бүсэд Казахстан, Герман, Монгол Улсын хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэх “Импактор Капитал Менежмент Монголия” ХХК-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 02 дугаар сарын 09-ний өдөр цахим уулзалтыг зохион байгуулж, уг төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын талаар зөвшилцсөн.</li> <li>- Дээрх төслийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөгөө авахаар Барилга хот байгуулалтын яам, нийслэлийн Хст байгуулалт, хөгжлийн газарт 02 дугаар сарын 17-ны өдрийн 14, 15 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлэн, 02 дугаар сарын 23-ны өдөр БХБЯ болон Барилгын хөгжлийн төзд уулзалт зөвлөгөөнд оролцож, төслийг хэрэгжүүлэх асуудлаар хэлэлцэж, улмаар салбарын яамдын оролцоотой төслийн нэгж байгуулахаар тогтов.</li> </ul>	100
<b>УДИРДЛАГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ</b>			

1	2	3	4
22.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.13	2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг <a href="http://www.old.ulaanbaatar.mn">www.old.ulaanbaatar.mn</a> сайтад 02 дугаар сарын 17-ны өдөр тайлагнасан. 02 дугаар сарын 22-ны өдрийн нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
23.		2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай хурал дээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган, биелэлтийг 02 дугаар сарын 17-ны өдрийн 16 дугаартай албан бичгээр дүүргийн Хот байгуулалтын хэлтэст, тус хэлтсийн Дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтний ERP хаягт тус тус хүргүүлсэн. 02 дугаар сарын 23-ны өдрийн дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100

ХЯНАСАН:  
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛЭГ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН,  
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗАЯА